

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Насан туршийн боловсролын төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2026/045/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Орхон аймаг
2025 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва

Утас: 70353088 Цахим хаяг: purevlkhagvap@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-Ундрах

Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

Аудитор: “Төгс нотолгоо аудит” ХХК-ийн Ахлах аудитор:
Г.Цэцэгмаа

Утас: 99889665 Цахим хаяг: tugsnotolgooaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, Эрх чөлөөний өргөн чөлөө-3,
Уртбулаг баг, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033
Утас: (976) 7035 9826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2026.02.07 № 22
танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН НАСАН
ТУРШИЙН СУРАЛЦАХУЙН ТӨВИЙН
ЗАХИРАЛ О.ОТГОНБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн насан туршийн суралцахуйн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн насан туршийн суралцахуйн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Орхон аймгийн хөрөнгө оруулалтаар 20,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж өгсөнийг санхүүгийн тайланд тусгасан байна.

Цаашид тус байгууллагын чиг үүрэг өөрчлөгдөж, татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын гол асуудал

Боловсролын салбарын байгууллагууд 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн 4 хоногийн ажил хаялтад нэгдэж, Хөдөлмөрийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 30.3-т "Ажил хаялтад оролцоогүй боловч түүнээс шалтгаалан ажил

үүргээ гүйцэтгэх боломжгүй байсан ажилтанд тухайн хугацаанд дундаж цалин хөлстэй тэнцэх хэмжээний олговрыг ажил олгогч олгоно" гэж заасны дагуу цалин хөлсөө авсан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 3 зорилт, 44 арга хэмжээг хэрэгжүүлэхээр Боловсролын ерөнхий газрын даргатай байгуулж, хэрэгжилтийг тайлант онд 95 хувьтай дүгнүүлсэн байна.

Боловсролын ерөнхий газрын шийдвэрээр байгууллагын оноосон нэрийг Насан туршийн боловсролын суралцахуйн төв болгож улсын бүртгэлийн гэрчилгээнд өөрчлөлт оруулсан байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитор аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА

ХОЁР. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	159,637,404.36	147,330,322.25
311	Кассанд байгаа бэлэн мөнгө		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	159,637,404.36	147,330,322.25
3121	Төгрөг	159,637,404.36	147,330,322.25
31211	Төрийн сангийн харилцах	159,637,404.36	147,330,322.25
314	Замд яваа мөнгөн хөрөнгө		
33	АВЛАГА		
34	УРЬДЧИЛГАА		
35	БАРАА МАТЕРИАЛ	15,415,212.20	14,879,862.20
351	Түүхий эд материал	14,589,112.20	14,809,112.20
3511	Тусгай зориулалттай материал	14,589,112.20	14,809,112.20
354	Хангамжийн материал	826,100.00	70,750.00
3541	Бичиг хэргийн материал	753,300.00	57,000.00
3542	Аж ахуйн материал	72,800.00	13,750.00
36	НӨӨЦИЙН БАРАА		
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	175,052,616.56	162,210,184.45
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	62,668,486.77	65,024,072.37
392	Биет хөрөнгө	62,668,486.77	65,024,072.37
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	81,577,564.00	104,063,909.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-25,317,833.73	-43,422,217.97
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	17,675,550.00	17,675,550.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-11,266,793.50	-13,293,168.66
39301	Програм хангамж	400,000.00	400,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-400,000.00	-400,000.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	62,668,486.77	65,024,072.37
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	237,721,103.33	227,234,256.82
51	Засгийн газрын хувь оролцоо	237,721,103.33	227,234,256.82
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	317,638,399.00	317,638,399.00
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө		
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		
51101	Өмч: - төрийн		
512	Хуримтлагдсан үр дүн	-792,184,784.96	-805,157,976.47
5121	Өмнөх үеийн үр дүн	-792,184,784.96	-792,184,784.96
5122	Тайлант үеийн үр дүн		-12,973,191.51
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	712,267,489.29	712,267,489.29
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	237,721,103.33	008
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	237,721,103.33	227,234,256.82

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	598,418,700.00	774,598,745.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	526,318,700.00	564,705,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	526,318,700.00	564,705,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	72,100,000.00	119,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	72,100,000.00	119,000,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	54,591,385.00	88,407,400.00
120	Нийтлэг татварын бус орлого	54,591,385.00	88,407,400.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	23,792,440.00	68,407,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	23,792,440.00	68,407,400.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	30,798,945.00	22,486,345.00
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	653,010,085.00	774,598,745.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	591,337,324.13	785,085,591.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	591,336,724.13	782,022,891.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	439,855,202.00	561,075,766.11
210101	Үндсэн цалин	276,752,256.00	333,006,843.93
210102	Нэмэгдэл	152,673,946.00	198,884,997.51
210103	Унаа хоолны хөнгөлөлт		16,018,787.00
210104	Урамшуулал	10,429,000.00	13,165,137.67
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,856,990.42	63,652,518.00
210201	Тэтгэврийн даатгал	34,642,711.86	43,284,191.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,061,121.37	5,092,132.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,020,610.23	2,546,015.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,017,128.98	2,546,015.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,115,417.98	10,184,165.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66,600,000.00	114,000,000.00
210304	Байрны түрээс	66,600,000.00	114,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,009,900.00	1,937,300.00
210604	Урсгал засвар	5,009,900.00	1,937,300.00
2107	Томилолт, зочны зардал		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,014,631.71	41,357,307.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,944,120.00	16,712,448.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,694,250.00	4,514,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	14,376,261.71	20,130,759.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	600	3,062,700.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	600	3,062,700.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	600	3,062,700.00
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		
	Дотоод эх үүсвэрээр		
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	591,337,324.13	785,085,591.51

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	61,672,760.87	10,486,846.51
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	587,550.34	
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	587,550.34	
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-587,550.34	
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	61,085,210.53	-10,486,846.51

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	622,211,140.00	752,112,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	23,792,440.00	68,407,400.00
120	Нийтлэг татварын бус орлого	23,792,440.00	68,407,400.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	23,792,440.00	68,407,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	23,792,440.00	68,407,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	598,418,700.00	683,705,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	526,318,700.00	564,705,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	526,318,700.00	564,705,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	72,100,000.00	119,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	72,100,000.00	119,000,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	578,923,262.42	764,419,482.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	578,923,262.42	764,419,482.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	578,922,662.42	761,356,782.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	439,855,202.00	561,075,766.11
210101	Үндсэн цалин	276,752,256.00	333,006,843.93
210102	Нэмэгдэл	152,673,946.00	198,884,997.51
210103	Унаа хоолны хөнгөлөлт		16,018,787.00
210104	Урамшуулал	10,429,000.00	13,165,137.67
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,856,990.42	63,652,518.00
210201	Тэтгэврийн даатгал	34,642,711.86	43,284,191.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,061,121.37	5,092,132.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,020,610.23	2,546,015.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,017,128.98	2,546,015.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,115,417.98	10,184,165.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66,600,000.00	114,000,000.00
210304	Байрны түрээс	66,600,000.00	114,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		
2105	Нормативт зардал		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,499,400.00	1,937,300.00
210604	Урсгал засвар	5,499,400.00	1,937,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,111,070.00	20,691,198.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,511,950.00	16,188,298.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,599,120.00	4,502,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	600	3,062,700.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	600	3,062,700.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	600	3,062,700.00

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	43,287,877.58	-12,307,082.11
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	43,287,877.58	-12,307,082.11
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		159,637,404.36
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		147,330,322.25

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцоо дүн
C01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	317,638,399.00	712,267,489.29	(792,184,784.96)	237,721,103.33
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	317,638,399.00	712,267,489.29	(792,184,784.96)	237,721,103.33
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-		-
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	317,638,399.00	712,267,489.29	(792,184,784.96)	237,721,103.33
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	317,638,399.00	712,267,489.29	(792,184,784.96)	237,721,103.33
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	317,638,399.00	712,267,489.29	(792,184,784.96)	237,721,103.33
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(10,486,846.51)	(10,486,846.51)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	317,638,399.00	712,267,489.29	(802,671,631.47)	227,234,256.82

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	842,903,800.00	761,356,782.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	842,903,800.00	761,356,782.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	842,903,800.00	761,356,782.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	613,781,200.00	561,075,766.11
210101	Үндсэн цалин	432,553,600.00	333,006,843.93
210102	Нэмэгдэл	167,064,000.00	198,884,997.51
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	16,018,787.00
210104	Урамшуулал	14,163,600.00	13,165,137.67
210105	Гэрээт ажлын хөлс		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	79,222,600.00	63,652,518.00
210201	Тэтгэврийн даатгал	53,871,400.00	43,284,191.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,337,800.00	5,092,132.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,168,900.00	2,546,015.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,168,900.00	2,546,015.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,675,600.00	10,184,165.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	114,000,000.00	114,000,000.00
210304	Байрны түрээс	114,000,000.00	114,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	1,937,300.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	1,937,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,900,000.00	20,691,198.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,300,000.00	16,188,298.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,600,000.00	4,502,900.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	773,195,000.00	752,112,400.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	564,705,000.00	564,705,000.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	564,705,000.00	564,705,000.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	119,000,000.00	119,000,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	119,000,000.00	119,000,000.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	89,490,000.00	68,407,400.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	89,490,000.00	68,407,400.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		159,637,404.36
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		147,330,322.25
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
610002	Төсвөөс гадуур байгууллага		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	18.00	18.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	13.00	13.00
620003	Үйлчлэх ажилтан	4.00	4.00
620004	Гэрээт ажилтан		
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	105.00	105.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	105.00	105.00

630001	Төрийн өмчит ЕБС	105.00	105.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	18.00	18.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)		
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)		
650003	Ажлын албаны албан хаагч (АА)		
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	12.00	12.00
650005	ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)		
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)		
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)		
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)		
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	6.00	6.00
650010	Гэрээт ажилтан		
650011	Улс төрийн албан хаагч (УТ)		

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,134.8 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 3,134.8 мянган мянган төгрөгийн алдааг залруулж тайлагналаа.

Залруулсан алдаа:

- ✓ Орон нутгийн нэмэгдэл санхүүжилтийн батлагдсан төлөвлөгөөг 648.4 төгрөгөөр дутуу тайлагнасан
- ✓ Үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 2,486.3 мянган төгрөгийн орлогыг зөрүүтэй тайлагнасныг тайлант хугацаанд залруулсан.

3.1 Төлбөрийн акт

2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогүй болно.

3.2 Албан шаардлага

2025 санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага хүргүүлээгүй болно.

3.3 Зөвлөмж

2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж хүргүүлээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Орон нутгийн нэмэгдэл санхүүжилтийн батлагдсан төлөвлөгөөг 648.4 төгрөгөөр дутуу тайлагнасан байна.	1	648.4					1	648.4				
Үр дүнгийн тайланд 2,486.3 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг зөрүүтэй тайлагнасан	1	2,486.3					1	2,486.3				
Дүн	2	3,134.8					2	3,134.8				